



АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИДЭР БАГИЙН  
ХАР ТОЛГОЙН 10 ГА МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ  
ТАРИАЛАХ ТАЛБАЙД УСАЛГААНЫ СИСТЕМ СУУРИЛУУЛАХ  
АЖИЛ

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

МУБХТХМОН/19/301/20240202006

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

<b>A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....</b>	<b>9</b>
1. Тендерийн цар хүрээ .....	9
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	9
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	9
4. Худалдан авах ажиллагааны цахим систем .....	9
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.....	9
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага.....	9
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага .....	10
<b>B. АГУУЛГА.....</b>	<b>10</b>
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	10
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	11
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	11
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах.....	11
<b>V. ТЕНДЕР БЭЛТГЭХ.....</b>	<b>11</b>
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	11
13. Тендерийн иж бүрдэл .....	12
14. Тендерийн жишиг маягтууд .....	12
15. Хувилбарт санал .....	12
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг .....	13
17. Чадавхын болон туршлагын шаардлага .....	13
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	13
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	14
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	14
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	14
22. Тендерийн валют .....	15
23. Тендер хүчинтэй байх хугацаа .....	15
24. Тендерийн баталгаа .....	15
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ .....</b>	<b>16</b>
25. Тендер баталгаажуулах, илгээх .....	16
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	16
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ .....</b>	<b>16</b>

27.	Тендерийн талаар тодруулга авах.....	16
28.	Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	16
29.	Тендерийг үнэлэх.....	17
30.	Арифметик алдааг залруулах .....	17
31.	Давуу эрх олгох.....	17
32.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	17
33.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	17
34.	Тендерийг эрэмбэлэх .....	17
35.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	17
E.	МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ .....	18
36.	Мэдэгдэл хүргүүлэх .....	18
37.	Гүйцэтгэлийн баталгаа .....	18
38.	Урьдчилгаа төлбөр .....	18
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах .....	18

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "ажил" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

#### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

#### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

#### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.

#### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

#### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

**7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**Б.АГУУЛГА**

**8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

- бэлтгэнэ.
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
- 9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.
- 9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж телсөн баримтыг хавсаргана.
- 9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.
- 9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.
- 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 10.1.Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 10.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.
- 10.3.ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.
- 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 11.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.
- 11.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллийс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг  
маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

**16. Ерөнхий шаардлагыг  
магадлах баримт бичиг**

тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцгийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн В бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьялалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцгийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцгийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

**17. Чадавхын болон  
туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**18. Санхүүгийн чадавхын  
шаардлагыг хангах нотлох**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага

баримт	<p>хангасан байна.</p> <p>18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p> <p>20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.</p> <p>20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.</p> <p>21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.</p> <p>21.2. Тендерт ирүүлэх өртийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх</p>
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	

- бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.
- 21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.
- 21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.
- 21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд серөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.
- 23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Төндер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бурд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

#### **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

##### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.** 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

##### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

##### **27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

##### **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар

- авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийт ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мэнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер "хамгийн сайн" гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

#### **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- |  |  |
|--|--|
| 36. Шийдвэр хүргүүлэх                      | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.  |
| 37. Гүйцэтгэлийн баталгаа                  | 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.<br>37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.   |
| 38. Урьдчилгаа төлбөр                      | 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.<br>38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.<br>38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.<br>38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна. |
| 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.<br>39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.  |



## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" МОН/19/301 төсөл
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр багийн Хар толгойн 10 га малын тэжээлийн ургамал тариалах талбайд усалгааны систем суурилуулах ажил, МУБХТХМОН/19/301/20240202006
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: МУБХТХМОН/19/301/20240202006
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: "Багцгүй"
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: "Үгүй"
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламж
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 44,290,480 төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" МОН/19/301 төслийн худалдан авалт хариуцсан мэргэжилтэн Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17023, Зайсангийн гудамж-9 Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв 311 тоот Утасны дугаар: +(976) 98281144 Цахим шуудангийн хаяг: info@ensure.mn
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: "Үгүй"
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: "Зөвшөөрөхгүй"
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: "Шаардана"  Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй эсэх;

	<p>Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй эсэх;</p> <p>Дээрх нөхцөл үүссэх эсэх мэдэгдэлийг оролцогч бичгээр гаргана.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: "Шаардана"</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны борлуулалтын орлогын хэмжээ батлагдсан төсөвт өртгийн дүнгийн 50 хувиас багагүй байх;</li> <li>- Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх;</li> <li>- Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт (Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх банк тус бүрээр)</li> </ul>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны санхүүгийн тайлан e-balance.mof.gov.mn цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ;</li> <li>- Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан НДШ болон татварын өр, төлбөргүй тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлэх;</li> <li>- Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлэх;</li> <li>- Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлэх;</li> </ul> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: "Шаардана"</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил гүйцэтгэх байгууллага нь 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх ба 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн ажилчидтай байх;</li> <li>• Сүүлийн 2 жилд хийсэн адил төстэй ажлын үр дүн. (акт, гэрээний хувь, тайланг хавсаргах);</li> <li>• Ажлын даалгаварын хавсралтад заасан тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, суурилуулах, тээвэрлэх хүргэх боломжтой байх.</li> <li>• Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: "Шаардана"</li> </ul>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>[ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож бичнэ. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 0, 0-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> <li>- Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшийн, түрээслэх гэх мэт);</li> <li>- Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.]</li> </ul>
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: "Шаардахгүй"
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "Тохиулахгүй тогтмол байна"

#### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Техникийн санал;</li> <li>- Ажил гүйцэтгэх хуваарь;</li> <li>- Тендерийн баримт бичгийн ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ;</li> <li>- Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлгийг ирүүлнэ;</li> <li>- Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүнд багтаан үйлчилгээг чанартай гүйцэтгэн, хүлээлгэн өгөх тухай баталгааг бичгээр ирүүлнэ;</li> <li>- Итгэмжлэл маягтын дагуу ирүүлнэ;</li> <li>- Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно;</li> <li>- Тендерт ирүүлэх бүх лавлагаа, тодорхойлолт нь тендер зарласан өдрөөс хойш авсан байх шаардлагатай.</li> </ul>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 07</p> <p>Цаг: 10 цаг 30 мин</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 07</p> <p>Цаг: 11 цаг 30 мин</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг:</p> <p>Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17023, Зайсангийн гудамж-9 Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв 311 тоот</p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: "Үгүй"

### Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

<b>ТШЗ Error! Reference source not found.</b>	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: "Тийм"</p> <p>Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</p>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 38.1</b>	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: "Үгүй"</p>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### **ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИДЭР БАГИЙН ХАР ТОЛГОЙН 10 ГА МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ ТАЛБАЙД УСАЛГААНЫ СИСТЕМ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

<b>1</b>	<b>Үндэслэл</b> <p>Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хетэлбэрийн газартай хамтран "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворталтыг хангах нь" төслийг 2019-2025 оны хооронд Архангай аймгийн Бөхөн шарын нуруунд хамаарах Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал сум, Завхан аймгийн нутаг Тарвагатайн нуруунд хамаарах Их-Уул, Тосонцэнгэл сум, Зармангийн говь, Улааншалын хоолойн нутагт хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Шинэжинст, Говь-Алтай аймгийн Цогт, Чандмань, Эрдэнэ суманд хэрэгжүүлж байна. Тус төсөл Саян, Хангайн уулс болон Өмнийн говийн бүс нутагт бэлчээр, ойн нөөцийн доройтлыг багасгах, биологийн олон янз байдлыг тогтвортой амьжирагаар дамжуулан хамгаалах замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах зорилготой.</p> <p>Өнөөдрийн байдлаар манай улсад бэлчээрийн газрын 65 орчим хувь нь доройтолд орж мал бэлчээрээс идэх ёвс тэжээлийн хэмжээ бараг 2 дахин багассан. Үүнээс шалтгаалан хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг, богийн гулуузны жин 13,9%-иар буурч байгааг мэргэжлийн байгууллага тогтоосон бөгөөд улмаар 2040 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн хавсарсан нөлөөгөөр 0.8-2.2 кг хүртэл буурах төлөвтэй байна. Ийнхүү малын тэжээлийн дутагдлаас үүдэлтэй малын ашиг шим буурч байгаа нь бэлчээрийн даац, ачааллыг хэтрүүлэхээс гадна экспортын зах зээлд Монгол малын махны үнэлгээ унах нэг нөхцөл болж малчин өрхийн орлогод сөрөг нөлөө үзүүлж байна.</p> <p>Орон нутгийн нөхцөлд малчид мал сүргийнхээ тэжээлийн хангамжийг сайжруулахын тулд бэлчээрийн ургац, даацыг нэмэгдүүлэх, тэжээл бэлтгэлийн бүх төрөл дээр нэмэгдүүлэх гэсэн 2 үндсэн арга хэмжээг бүлгээрээ хамтран хэрэгжүүлэх талаар малчдын бүлгийн 5 жилийн цогц төлөвлөгөөнд тусгасан. Ингэснээр орон нутагт хадлан, тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, бэлчээрийн ачааллыг бууруулах улмаар</p>
----------	--


		<p>бэлчээрийн Монгол малын ашиг шим, тэсвэрт чанарыг сайжруулах, ган зудын эрсдлийг багасгах, малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.</p> <p>Иймээс төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.5в дахь “Тэжээлийн ургамал тариалахад зориулсан усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх” үйл ажиллагааг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр багийн Хар толгойд байрлах 10 га хашаалсан талбайд малын тэжээлийн ургамал тариалах, төсөлд хамрагдсан малчны бүлгүүдийг дэмжих, талбайгаас авах ургацийн хэмжээг нэмэгдүүлэх зорилготой усалгааны систем суурилуулах ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан болно.</p>
2	<b>Зорилго</b>	Төслийн бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах зорилтын хүрээнд байгуулагдсан малчны бүлгүүдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, ган, зуд, цаг агаарын гэнэтийн онц аюултай үзэгдлээс үүсч буй эрсдэлийн нөлөөг багасгах, мал сүргийн таваарлаг байдлыг дээшлүүлэхийн тулд тэжээл бэлтгэлийн чанарыг сайжруулах
3	<b>Зорилт</b>	Нэгж талбайгаас авах ургацийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулсан газар тариалангийн усалгааны систем нийлүүлэх.
4	<b>Гүйцэтгэх ажил</b>	<p>Энэхүү гэрээт ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Голын уснаас 200 м зайд байрлах 10 га талбайг бүрэн услах хүчин чадалтай байх (Хавсралтад заасан техникийн тодорхойлолтын дагуу);</li> <li>Усалгааны системийг тариалангийн талбайд бүрэн суурилуулж хүлээлгэн өгөх;</li> <li>Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжөөр хангах;</li> <li>Ашиглагчаас үл шалтгаалсан аливаа эвдрэл гэмтэлд нэг жилийн батлагаа гарах;</li> </ul>
5	<b>Хамрах хүрээ</b>	Завхан аймгийн Тосонцэнгэл сум Идэр баг Хар толгой
6	<b>Хүлээлгэн өгөх ажлын үр дүн</b>	10 га талбайг бүрэн услах хэмжээгээр усалгааны системийн хүчин чадлыг тооцоолон, техникийн тодорхойлолтод заасан техник хэрэгслүүдийг нийлүүлж, суурилуулан сумын ЗДТГ болон төслийн ажилтанд хөрөнгө хүлээлцэх актаар хүлээлгэн өгсөн байна.
7	<b>Ажил гүйцэтгэгчид тавих шаардлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх байгууллага нь 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх ба 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн ажилчидтай байх;</li> <li>Сүүлийн 2 жилд хийсэн адил төстэй ажлын үр дүн. (акт, гэрээний хувь, тайланг хавсаргах);</li> <li>Хавсралтад заасан тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, суурилуулах, тээвэрлэж хүргэх боломжтой байх.</li> </ul>
8	<b>Ажил гүйцэтгэх хугацаа тайлангийн</b>	<p>Эхлэх хугацаа: 2024 оны 11 дугаар сарын 25-ны өдөр</p> <p>Дуусах хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр</p>

	<b>бүрдэл, зохион байгуулалт</b>	<p>2024 оны 11 дугаар сарын 25-ны дотор эхлэлийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагч талаар баталгаажуулсны дараа нийт төлбөрийн 60%-ийг төлнө</li> </ul> <p>2024 оны 12 дугаар сарын 20 -ны өдөр эцсийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн хугацаанд боловсруулсан бүхий л төлөвлөгөө, тайлан, хүлээлцсэн акт, баримт бичгийг эцсийн тайлантай хамт захиалагч талд хүлээлгэн өгсний дараа нийт төлбөрийн үлдэгдэл 40%-ийг төлнө.</li> </ul> <p>Ажил гүйцэтгэгч нь дээрх хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгж, НҮБХХ-ийн газар болон бусад холбогдох төв, орон нутгийн түвшний оролцогч талуудтай нягт хамтран ажиллана. Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч нь учирч болзошгүй эрсдэлийг цаг хугацаанд нь олж тогтоох, үүнээс үүдэн үйлчилгээ үзүүлэх хугацаа ямар нэгэн байдлаар хэтрэхээр бол энэ тухай урьдчилан мэдэгдэж ажиллана.</p>
9	<b>Мэдээллийн нууцлал</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан бичгийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Ажлын хүрээнд боловсруулсан хөтөлбөр, мэдээлэл, төлөвлөгөө, тайлан зэрэг баримт бичиг нь захиалагч талын өмч байна.
10	<b>Захиалагч байгууллага</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтвортжилтыг хангах нь” МОН/19/301 төсөл

**Хавсралт № 1. ШААРДАГДАХ МАТЕРИАЛЫН ЖИШИГ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙПОЛТ**

<b>№</b>	<b>Бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нэр төрөл</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо ширхэг</b>
1.	Мото помп	ширхэг	1
2.	Бороожуулагч хошуу	ширхэг	1050
3.	Үндсэн хоолой /50 мм-тэй/	метр	1200
4.	Нарийн хоолой /20 мм-тэй/	Метр	14000
5.	50 мм диаметртэй гуравтай салаалагч	ширхэг	3
6.	Эмээл /50 мм-тэй үндсэн хоолойны/	ширхэг	70
7.	Хаалт /50 мм-тэй үндсэн хоолойны/	ширхэг	70
8.	Булан холбогч /50 мм-тэй үндсэн хоолойны/	ширхэг	15
9.	Шулуун холбогч /50мм Үндсэн хоолойны/	ширхэг	10
10.	Шулуун холбогч /20мм Нарийн хоолой/	ширхэг	30
11.	Хоолойн таг /50мм Үндсэн хоолой ашиглах/	ширхэг	5
12.	Хоолойн таг /50мм Нарийн хоолойд ашиглах/	ш	70
	<b>Нийт дүн</b>		

**1. НЭР ТӨРӨЛ: Бензин Мото помп**

	Материалын орц	Төмөр	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	300*350 хэмжээтэй, голоос 200м зайд байрлах 10 га талбайд сууринуулсан усалгааны системд ашиглах, 1 цагт 50 тн ус шахах хүчин чадалтай, 5 м шланк хоолойнуудын хамт байх	

**2. НЭР ТӨРӨЛ: Бороожуулагч хошуу**

	Материалын орц	Полиэтилен РЕ	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	

1.3	Үзүүлэлт	Тухайн талбайг бүрэн услах хэмжээний сайн чанарын бороожуулагч хошуу	
-----	----------	--	--

### 3. НЭР ТӨРӨЛ: Үндсэн хоолой

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	


### 4. НЭР ТӨРӨЛ: Нарийн хоолой

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	

### 5. НЭР ТӨРӨЛ: 50 мм диаметртэй гуравтай салаалагч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	

### 6. НЭР ТӨРӨЛ: Эмээл + хаалт

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн эмээл + 20 мм хоолойны хаалт	

### 7. НЭР ТӨРӨЛ: Булан холбогч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн булан холбогч	

### 8. НЭР ТӨРӨЛ: Шулуун холбогч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм болон 20 мм диаметртэй хоолойн шулуун холбогч	

### 9. НЭР ТӨРӨЛ: Хаалт

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн Хаалт	

### 10. НЭР ТӨРӨЛ: Хоолойн таг

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	

1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн таг	

## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Төндер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

## Маягт 1. Тендер илгээх

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо] өдрийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна." гэж сольж бичнэ үү.

7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

**Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл**

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

**Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

Машин механизмын нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	[“Өөрийн эзэмшил” эсхүл “турээс” аль нэгийг бичих]

**Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

### Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд запруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дунд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. "Захиалагч" гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.2. "Захиалагчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.3. "Гүйцэтгэгч" гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. "Гүйцэтгэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.5. "Талууд" гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
  - 1.1.6. "Хууль" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. "Ажил" гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
  - 1.1.8. "Ажлын талбай" гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
  - 1.1.9. "Баталгаат хугацаа" гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
  - 1.1.10. "Гомдлын шаардлага гаргах хугацаа" гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.11. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хел хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

- |         |  |
|---------|--|
| Тайлбар | <ol style="list-style-type: none"> <li>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:           <ol style="list-style-type: none"> <li>1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.</li> <li>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</li> <li>1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</li> <li>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</li> <li>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</li> </ol> </li> </ol> |
|---------|--|

#### **ХОЁР. ЗАХИАЛАГЧ**

- |                        |         |  |
|------------------------|---------|--|
| Захиалагчийн<br>үүрэг  | нийтлэг | <ol style="list-style-type: none"> <li>2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнэ.</li> <li>2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнэ.</li> <li>2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.</li> </ol> |
| Захиалагчийн төлөөлөгч |         | <ol style="list-style-type: none"> <li>2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.</li> <li>2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</li> <li>2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</li> </ol>  |
| Талбайд<br>зөвшөөрөл   | нэвтрэх | <ol style="list-style-type: none"> <li>2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.</li> <li>2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.</li> </ol>   |

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- |  |  |
|--|--|
| Гүйцэтгэгчийн<br>үүрэг                   | <p>НИЙТЛЭГ 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.</p> <p>3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.</p> <p>3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.</p> <p>3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> <p>3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нэхцэлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.</p> |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч                  | <p>3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.</p> <p>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.</p>  |
| Техникийн болон ажлын<br>талбайн өгөгдөл |  |
| Ажлын талбайн харуул<br>хамгаалалт       |  |

- |                                   |   |
|-----------------------------------|---|
| Хог, хаягдал ба нөхөн<br>сэргээлт | 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.<br>3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.<br>3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.   |
| Археологийн болон бусад олдвор    | 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.   |
| Аюулгүй байдал                    | 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.<br>3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.<br>3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.<br>3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нэлөөллөөс хамгаална.<br>3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.<br>3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.<br>3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.<br>3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана. |

#### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН**

- |            |  |
|------------|--|
| Ажил эхлэх | 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.<br>4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хургуулнэ.<br>4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын |
|------------|--|

- Хугацаа сунгах
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
  - 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
    - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
    - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
    - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
    - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
  - 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
  - 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
  - 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
  - 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
  - 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- Гэрээний үнэ
- 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
  - 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
  - 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

- |                   |   |
|-------------------|---|
| Урьдчилгаа төлбөр | <p>5.4. Төндер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>   |
| Төлбөрийн нэхцөл  | <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнэ.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн ёгех хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |

### **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                       |  |
|-----------------------|--|
| Урьдчилгаа баталгаа   | <p>6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.</p>   |
| Гүйцэтгэлийн баталгаа | <p>6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>6.3. Захиалагч дараах нэхцөл бий болсон тохиолдолд Үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> <p>6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> |

- |                          |   |
|--------------------------|---|
|                          | <p>6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.</p>  |
| <p>Чанарын баталгаа</p>  | <p>6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сутгаж, баталгаат хугацаа дусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> |
| <p>Баталгаат хугацаа</p> | <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p>  |

#### **ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ**

- |                                |   |
|--------------------------------|---|
|                                | <p>Бусдад учруулсан 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p> |
| <p>Захиалагчийн<br/>эрсдэл</p> | <p>хүлээх 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжктэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p>  |

- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

#### **НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**

- Доголдлыг арилгах илрүүлэх,
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

- |                          |   |
|--------------------------|---|
|                          | <p>8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.</p> <p>Далд доголдол</p> <p>8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>Зураг төслийн доголдол</p> <p>8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.</p> <p>8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.</p>  |
| <b>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</b> |   |
| Захиалагч гэрээг цуцлах  | <p>9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;</p> <p>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гаралаагүй;</p> <p>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</p> <p>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</p> <p>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нэхцэлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нэхцэлийг хангахгүй болсон.</p> <p>9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.</p> <p>Гүйцэтгэгч гэрээг цуцлах</p> <p>9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</p> <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> |

- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сэргээр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зерчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харицаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгэнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
  - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
  - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

Төлөөлөгч өөрчлөгдхөн

Ажилд өөрчлөлт,  
залруулга хийх нөхцөл

- |   |   |  |
|---|---|--|
| <p>Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал</p> <p>Оюуны өмчийн эрх зөрчих</p> <p>Алданги</p> | <p>буоу хүчний нэхцэл</p> <p></p> <p></p> | <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нэхцэл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нэхцэл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p> <p>10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>10.21. Захиалагч нь төлбөр телэх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнэ.</p> <p>10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнэ.</p> <p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p> |
|---|---|--|

Маргаан шийдвэрлэх

- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцэж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 25
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 20
ГЕН 4.9.	<p>Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: Эхлэх хугацаа: 2024 оны 11 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>Дуусах хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр</p> <p>2024 оны 11 дугаар сарын 25-ны дотор эхлэлийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагч талаар баталгаажуулсны дараа нийт төлбөрийн 60%-ийг төлнэ</li> </ul> <p>2024 оны 12 дугаар сарын 20 -ны өдөр эцсийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн хугацаанд боловсруулсан бүхий л төлөвлөгөө, тайлан, хүлээлцсэн акт, баримт бичгийг эцсийн тайлантай хамт захиалагч талд хүлээлгэн өгсний дараа нийт төлбөрийн үлдэгдэл 40%-ийг төлнэ.</li> </ul>
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: "Хийхгүй"
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: "Үгүй"
ГЕН 5.6.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p>2024 оны 11 дугаар сарын 25-ны дотор эхлэлийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагч талаар баталгаажуулсны дараа нийт төлбөрийн 60%-ийг төлнэ</li> </ul> <p>2024 оны 12 дугаар сарын 20 -ны өдөр эцсийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн хугацаанд боловсруулсан бүхий л төлөвлөгөө, тайлан, хүлээлцсэн акт, баримт бичгийг эцсийн тайлантай хамт захиалагч талд хүлээлгэн өгсний дараа нийт төлбөрийн үлдэгдэл 40%-ийг төлнэ.</li> </ul>
ГЕН 6.7.	<p><b>Чанарын баталгаа:</b></p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: "Шаардана"</p> <p>Чанарын баталгаа шаардах бол,</p> <p>Чанарын баталгааны хэмжээ: Гэрээний үнийн дунгийн 5 хувь байна.</p>
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: Ажил эхэлсэнээс хойш 10 сарын хугацаанд хүчинтэй байна.

ГЕН 7.5.	<b>Даатгал:</b> Гэнэтийн ослын, амь нас, эрүүл мэндийн хувьд гэрээнд хэрэглэх хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалын төлбөрийн зөвлөх өөрөө хариуцна.
ГЕН 10.22.	<b>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</b> Алдангийн хувь: хоног тутамд 0.2 хувь байна.

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИДЭР БАГИЙН ХАР ТОЛГОЙН 10 ГА  
МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ ТАЛБАЙД УСАЛГААНЫ СИСТЕМ  
СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ.

Дугаар № МУБХ/ХМОН/19/301/2024/0209006

2024 оны 11 сарын 25 Дугаар:

Улаанбаатар

Нэг талаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Монголын унаган захирал Ц.Уранчимэг (цаашид "Захиалагч" гэх), негee талаас [Гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Ажил" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

- Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
- Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
- Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Гэрээний өрөнхий нөхцөл;
  - Гүйцэтгэлийн баталгаа;
  - Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - Техникийн тодорхойлолт;
  - Ажил гүйцэтгэх хуваарь.
- Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 10 дугаар сарын 28**  
Тендер шалгаруулалтын төрөл: Ажил  
Тендер шалгаруулалтын нэр: Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр багийн Хар толгойн 10 га малын тэжээлийн ургамал тариалах талбайд усалгааны систем сууринуулах ажил  
Тендер шалгаруулалтын дугаар: МУБХХМОН/19/301/2024/02/2006  
Нийт төсөвт өртөг: **44,290,480 төгрөг**  
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Монголын унаган байгалийн хүлцэл тогвортолтыг хангах нь МОН/19/301 төсөл нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ “Үгүй”
- Тендерийг **2024 оны 11 дүгээр сарын 07-ны 10 цаг 30 минутаас өмнө** тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн, 11 цагт** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: “Үгүй”
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17023, Зайсангийн гудамж-9 Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, 311 тоот  
Утасны дугаар: 976-98281144  
Цахим шуудангийн хаяг: info@ensure.mn

БАТЛАВ  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН  
ЯМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН УЧИЙГ ТҮР ОРЛООН ГҮҮЦЭТГЭГЧ  
С.ЦОЛГЭРЭЛ

2024 оны 06 дугаар сарын ....-ны өдөр

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИДЭЭ БАГИЙН ХАР ТОЛГОЙН 10 ГА  
МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ ТАЛБАЙД УСАЛГААНЫ СИСТЕМ  
СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар

1	Үндэслэл	<p>Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хетэлбэрийн газартай хамтран "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворталтыг хангах нь" төслийг 2019-2025 оны хооронд Архангай аймгийн Бөхөн шарын нуруунд хамаарах Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал сум, Завхан аймгийн нутаг Тарвагатайн нуруунд хамаарах Их-Уул, Тосонцэнгэл сум, Зармангийн говь, Улааншалын холойн нутагт хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Шинэжинст, Говь-Алтай аймгийн Цогт, Чандмань, Эрдэнэ суманд хэрэгжүүлж байна. Тус төсөл Саян, Хангайн уулс болон Өмнийн говийн бус нутагт бэлчээр, ойн неецийн доройтлыг багасгах, биологийн олон янз байдлыг тогтвортой амьжиргаагаар дамжуулан хамгаалах замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах зорилготой.</p> <p>Өнөөдрийн байдлаар манай улсад бэлчээрийн газрын 65 орчим хувь нь доройтолд орж мал бэлчээрээс идэх ёвс тэжээлийн хэмжээ бараг 2 дахин багассан. Үүнээс шалтгаалан хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг, богийн гулуузны жин 13,9%-иар буурч байгааг мэргэжлийн байгууллага тогтоосон бөгөөд улмаар 2040 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн хавсарсан нөлөөгөөр 0.8-2.2 кг хүртэл буурах төлөвлөй байна. Ийнхүү малын тэжээлийн дутагдлаас үүдэлтэй малын ашиг шим буурч байгаа нь бэлчээрийн даац, ачааллыг хэтрүүлэхээс гадна экспортын зах зээлд Монгол малын махны үнэлгээ унах нэг нөхцөл болж малчин өрхийн орлогод сөрөг нелөө үзүүлж байна.</p> <p>Орон нутгийн нөхцөлд малчид мал сүргийнхээ тэжээлийн хангамжийг сайжруулахын тулд бэлчээрийн ургац, даацыг нэмэгдүүлэх, тэжээл бэлтгэлийн бүх төрөл дээр нэмэгдүүлэх гэсэн 2 үндсэн арга хэмжээг бүлгээрээ хамтран хэрэгжүүлэх талаар малчдын бүлгийн 5 жилийн цогц төлөвлөгөөнд тусгасан. Ингэснээр орон нутагт хадлан, тэжээлийн неөц хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, бэлчээрийн ачааллыг бууруулах улмаар бэлчээрийн Монгол малын ашиг шим, тэсвэрт чанарыг сайжруулах, ган зудын эрсдлийг багасгах, малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.</p>
---	----------	--

		Иймээс төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.5в дахь "Тэжээлийн ургамал тариалахад зориулсан усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх" үйл ажиллагааг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр багийн Хар толгойд байрлах 10 га хашаалсан талбайд малын тэжээлийн ургамал тариалах, төсөлд хамрагдсан малчны бүлгүүдийг дэмжих, талбайгаас авах ургацийн хэмжээг нэмэгдүүлэх зорилготой усалгааны систем суурилуулах ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан болно.
2	Зорилго	Төслийн бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах зорилтын хүрээнд байгуулагдсан малчны бүлгүүдийн амьжиригаанд дэмжлэг үзүүлэх, ган, зуд, цаг агаарын гэнэтийн онц аюултай үзэгдлээс үүсч буй эрсдэлийн нелөөг багасгах, мал сургийн таваарлаг байдлыг дээшлүүлэхийн тулд тэжээл бэлтгэлийн чанарыг сайжруулах
3	Зорилт	Нэгж талбайгаас авах ургацийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулсан газар тариалангийн усалгааны систем нийлүүлэх.
4	Гүйцэтгэх ажил	Энэхүү гэрээт ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Голын уснаас 200 м зайд байрлах 10 га талбайг бүрэн услах хүчин чадалтай байх (Хавсралтад заасан техникийн тодорхойлолтын дагуу);</li> <li>Усалгааны системийг тариалангийн талбайд бүрэн суурилуулж хүлээлгэн өгөх;</li> <li>Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжөөр хангах;</li> <li>Ашиглагчаас үл шалтгаалсан аливаа эвдрэл гэмтэлд нэг жилийн батлагаа гарах;</li> </ul>
5	Хамрах хүрээ	Завхан аймгийн Тосонцэнгэл сум Идэр баg Хар толгой
6	Хүлээлгэн өгөх ажлын үр дүн	10 га талбайг бүрэн услах хэмжээгээр усалгааны системийн хүчин чадлыг тооцоолон, техникийн тодорхойлолтод зассан техник хэрэгслүүдийг нийлүүлж, суурилуулан сумын ЗДТГ болон төслийн ажилтанд хөрөнгө хүлээлцэх актаар хүлээлгэн өгсөн байна.
7	Ажил гүйцэтгэгчид тавих шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх байгууллага нь 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх ба 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн ажилчидтай байх;</li> <li>Сүүлийн 2 жилд хийсэн адил төстэй ажлын үр дүн. (акт, гэрээний хувь, тайланг хавсаргах);</li> <li>Хавсралтад заасан тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, суурилуулах, тээвэрлэж хүргэх боломжтой байх.</li> </ul>
8	Ажил гүйцэтгэх хугацаа тайлангийн бүрдэл, зохион байгуулалт	<p>Эхлэх хугацаа: 2024 оны 07 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>Дуусах хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>2024 оны 07 дугаар сарын 25-ны дотор эхлэлийн тайлан.</p>

		<ul style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагч талаар баталгаажуулсны дараа нийт төлбөрийн 60%-ийг төлнэ</li> </ul> <p>2024 оны 10 дугаар сарын 20 -ны өдөр эцсийн тайлан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн хугацаанд боловсруулсан бүхий л төлөвлөгөө, тайлан, хүлээнлцсэн акт, баримт бичгийг эцсийн тайлантай хамт захиалагч талд хүлээлгэн өгсний дараа нийт төлбөрийн үлдэгдэл 40%-ийг төлнэ.</li> </ul> <p>Ажил гүйцэтгэгч нь дээрх хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгж, НҮБХХ-ийн газар болон бусад холбогдох төв, орон нутгийн түвшний оролцогч талуудтай нягт хамтран ажиллана. Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч нь учирч болзошгүй эрсдэлийг цаг хугацаанд нь олж тоогоо, үүнээс үүдэн үйлчилгээ үзүүлэх хугацаа ямар нэгэн байдлаар хэтрэхээр бол энэ тухай урьдчилан мэдэгдэж ажиллана.</p>
9	Мэдээллийн нууцлал	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан бичгийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Ажлын хүрээнд боловсруулсан хөтөлбөр, мэдээлэл, төлөвлөгөө, тайлан зэрэг баримт бичиг нь захиалагч талын өмч байна.
10	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй "Монголын Унаган Байгалийн Хүлцэл, Тогтвортжилтыг хангах нь" МОН/19/301 төсөл
11	Төсөвт өртөг	44,034,000 (дөчин дөрвөн сая гучин дөрвөн мянга) төгрөг

**Танилцсан:**

Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга,  
төслийн захирал

Ч.Уранчимэг

**Хянасан:**

"Монголын Унаган Байгалийн Хүлцэл, Тогтвортжилтыг хангах нь"  
төслийн үндэсний зохицуулагч

Б.Эрдэнэбилэг

**Боловсруулсан:**

"Монголын Унаган Байгалийн Хүлцэл, Тогтвортжилтыг хангах нь"  
төслийн мэргэжилтэн

Т.Энэрэл

**Хавсралт № 1. ШААРДАГДАХ МАТЕРИАЛЫН ЖИШИГ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1.	Мото помп	ширхэг	1
2.	Бороожуулагч хошуу	ширхэг	1050
3.	Үндсэн хоолой /50 мм-тэй/	метр	1200
4.	Нарийн хоолой /20 мм-тэй/	Метр	14000
5.	50 мм диаметртэй гуравтай салаалагч	ширхэг	3
6.	Эмээл /50 мм-тэй үндсэн хослойны/	ширхэг	70
7.	Хаалт /50 мм-тэй үндсэн хослойны/	ширхэг	70
8.	Булан холбогч /50 мм-тэй үндсэн хослойны/	ширхэг	15
9.	Шулуун холбогч /50мм Үндсэн хослойны/	ширхэг	10
10.	Шулуун холбогч /20мм Нарийн хоолой/	ширхэг	30
11.	Хоолойн таг /50мм Үндсэн хоолой ашиглах/	ширхэг	5
12.	Хоолойн таг /50мм Нарийн хоолойд ашиглах/	ш	70
	<b>Нийт дүн</b>		

**1. НЭР ТӨРӨЛ: Бензин Мото помп**

	Материалын орц	Төмөр	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	300*350 хэмжээтэй, голоос 200м зайд байрлах 10 га талбайд сууринуулсан усалгааны системд ашиглах, 1 цагт 50 тн ус шахах хүчин чадалтай, 5 м шланк хоолойнуудын хамт байх	

**2. НЭР ТӨРӨЛ: Бороожуулагч хошуу**

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	Будаггүй байх	

1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Тухайн талбайг бүрэн услах хэмжээний сайн чанарын бороожуулагч хошуу	

### 3. НЭР ТӨРӨЛ: Үндсэн хоолой

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх <th data-kind="ghost"></th>	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	

### 4. НЭР ТӨРӨЛ: Нарийн хоолой

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	Будаггүй байх	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх <th data-kind="ghost"></th>	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	

### 5. НЭР ТӨРӨЛ: 50 мм диаметртэй гуравтай салаалагч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх <th data-kind="ghost"></th>	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй, Хананы зузаан: 2.8 мм	

### 6. НЭР ТӨРӨЛ: Эмээл + хаалт

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн эмээл + 20 мм хоолойны хаалт	

#### 7. НЭР ТӨРӨЛ: Булан холбогч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн булан холбогч	

#### 8. НЭР ТӨРӨЛ: Шулуун холбогч

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм болон 20 мм диаметртэй хоолойн шулуун холбогч	

#### 9. НЭР ТӨРӨЛ: Хаалт

	Материалын орц	Полиэтилен PE	
1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн Хаалт	

#### 10. НЭР ТӨРӨЛ: Хоолойн таг

	Материалын орц	Полиэтилен PE	

1.1	Өнгө	-	
1.2	Чанар	Үйлдвэрийн болон тээвэрлэлтийн гэмтэлгүй байх	
1.3	Үзүүлэлт	Гадаад диаметр: 50 мм диаметртэй хоолойн таг	

--oOo--

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСТАЛЬН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙЛЫН  
ТУШААЛ

2024 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 4/396

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дахь хэсэг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг Төрийн болон брон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, түйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтийн 50.5 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хооронд 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворталтыг хангах нь" МОН/19/301 төслийн баримт бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворталтыг хангах нь" МОН/19/301 төслийн хурээнд "Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр багийн Хар толгойн 10 га малын тэжээлийн ургамал тариалах талбайд усалгааны систем суурилуулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Хандармаа (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн неөцийн бодлопын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Ч.Дэлгэрзаяа (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн)

С.Балжиням ("Хүний хөгжил, сургалт судалгааны төв" ТББ-ын гишүүн)

А.Оюунчимэг ("Булаг шанд гол мөрний эхийн хамгаалах сан" ТББ-ын тэргүүн)

Нарийн бичиг:

Х.Цэгмидзаяа (Монголын унаган байгалийн хүлцэл тогтворталтыг хангах нь МОН/19/301 төслийн 9-р хувийн аймгийн зохицуулагч)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дасуу зоржон байгуулах

1004 OHB 10 cap. 02

四

1